

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн уриа: Хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт

Нэг. Эдийн засгийн өсөлтийг хангах бодлого.

1.1. Сумын ДНБ-ний үйлдвэрлэлийг жил бүр өсгөж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг "Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого"ын баримт бичигт заасан хэмжээнд хүргэх.

1.2. Сумандаа ахуйн үйлчилгээ, гар урлал, гутал, оёдлын цех, үйлдвэрийг байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

1.3. "Баянхонгорт үйлдвэрлэв" сүлжээ дэлгүүрийг сумандаа байгуулж орон нутгийн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4. Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулалтын ЖДҮ-ийг зориулалтын сангуудаар дэмжиж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнийгээ зах зээлд борлуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

1.5. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ биржийн худалдаа, цахим худалдаагаар борлуулах хэлбэрт шилжиж, зах зээлийн үнийн эрсдлээс хамгаалж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

1.6. Төмс хүнсний ногоогоор нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, энэ үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх.

Хоёр. Хувь хүний хөгжил, эрх чөлөө

2.1. Боловсрол

2.1.1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ. Багшийн хангажийг сайжруулна.

2.1.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлнэ.

2.1.3. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд ААН, байгууллагуудыг дэмжинэ.

2.1.4. Сургууль цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын засвараар үе шаттай хангаж, сургууль, цэцэрлэгийн удирдлагын чадавхийг сайжруулна.

2.1.5. Анги дэвших төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангиа 60-аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгуулсан багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.1.6. Цэцэрлэг шинээр барих асуудлыг шийдэж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтад малчдын хүүхдийг бүрэн хамруулна.

2.1.7. Багш солилцох бодлогыг хэрэгжүүлж,ЕБС-ийн сургалтын чанар амжилтыг улсын дунджаас дээшлүүлнэ.

2.1.8. Сумын болон Амарбуяантын бүсийн онцлогтой урлаг, соёлын биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, сурталчлах, залуу үедээ уламжлуулан өвлүүлэхийг бодлогоор дэмжинэ. Өрх бүрээр угийн бичиг хөтлүүлнэ.

2.2.Эрүүл мэнд

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг байнга дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны үзлэг,оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ.

2.2.2. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн өрсөлдөх чадвар сайтай хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлэх

2.2.3. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, сургалтанд хамруулах,ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.4. Сумын эрүүл мэндийн төвийг мэргэжлийн эмч, мэргэжилтэн, шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангаж, стандартын дагуу хийгдэх шинжилгээ, ерөнхий болон төрөх эмэгтэйчүүдийн мэс засал хийдэг болно.

2.2.5.Эх, нялхсын эндэгдлийг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүртэл бууруулна..

2.2.6.Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,нийгмийн хамгаалал

2.3.1. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, төв суурингийн өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2. Өрхийн үйлдвэрллийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.3. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан ААН-үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.3.4. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж,тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвхи санаачилга, боломжийг дэмжиж, хөгжүүлнэ.

2.3.5. Залуу гэр бүлийг эхний ээлжинд ажлын байр, хөнгөлөлттэй тохилог сууцанд хамруулах, оюутан залуусыг дэмжих бодлого баримтална.

Гурав. Хөдөө аж ахуй,Байгаль орчин

3.1. Мал аж ахуй

3.1.1. Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална.

6417143
140067 9



3.1.2. Сүргийн бүтэц, эргэлтийг сайжруулж, МАА-гаас ашиглах сүү, цагаан идээ, мах, ноос ноолуур түүхий эдийг биржийн худалдаа, цахим худалдаагаар борлуулах хэлбэрт шилжиж, зах зээлийн үнийн эрсдлээс хамгаалж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

3.1.3. Сумын хонин сүрэгт Баяд үүлдрийг сайжруулагчаар ашиглаж, амьдын жин, махны гарцыг нэмэгдүүлнэ.

3.1.4. Сумын ямаан сүрэгт "Залаажинстийн цагаан" ямааг сайжруулагчаар ашиглаж, нэгжээс авах ноолуурын гарц, чанарыг тогтвортой түвшинд байлгах, сайжруулах.

3.1.5. Бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах, хөв цөөрөм байгуулах, малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээг "Малын эрсдэлийн сан"гийн хөрөнгөөр шийддэг байх орчинг бүрдүүлнэ.

3.1.6. Багт угаалгын ванн, бууц ариутгах цистерн зэрэг тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах бодлогыг дэмжинэ.

3.1.7. Бог малыг хашаажуулах бодлого барина.

3.1.8. Бэлчээрт худаг уст цэг шинээр гаргасан малчдыг урамшууддаг тогтолцоог бүрдүүлнэ.

3.1.9. Баг бүрт малын эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулж, Малын эмч, мал зүйчдийн хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.

3.2. Газар тариалан:

3.2.1. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн сумын хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр хангахыг зорьж, хэрэгжүүлнэ.

3.2.2. МАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн, ӨМӨЗО- той хамтран малчин өрхүүдэд төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал тариалах ажлыг туршиж, хэрэгжүүлнэ.

3.2.3. Тохиромжтой газруудад 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалалтыг хөгжүүлэх.

3.2.4. Жил бүр мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын үеийн 7 хоногт шаардлагатай хадлан тэжээлийг бэлтгэнэ.

3.2.5. Төмс, хүнсний ногооны стандарт зоорь, малын тэжээлийн агуулах барьж ашиглах асуудлыг төсөл хөтөлбөрөөр шийдвэрлэнэ.

3.2.6. Сумын газар тариалангийн бүсэд байгаа услалтын системүүдийн сэргээн засварлаж, бүрэн ашиглана.

3.3. Тогтвортой байгаль орчин

3.3.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг одоогийн түвшингээс 4 дахин нэмэгдүүлнэ.


3.3.2. Өрх бүр хашаандаа, өвөлжөөндөө мод тарих хөдөлгөөн өрнүүлнэ.

3.3.3. Хөдөөгийн эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.3.4. Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландфилын аргаар дарна.

3.3.5. Гол горхи, булаг шандны эхийг хамгаалах, ойжуулах, модлог ургамлуудыг тариалах, ногоон массыг нэмэгдүүлэх.

544
007423



000000003

3.3.6. Нүүдлийн МАА-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.3.7. Говь-Алтай аймгийн Чандмана сум , Баянхонгор аймгийн Баянцагаан сум хоорондын хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх

Дөрөв. Хуулиа дээдэлдэг, иргэддээ үйлчилдэг засаглал

4.1.Сайн засаглал

4.1.1.Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг засаглалыг төлөвшүүлнэ.

4.1.2.Төрийн байгууллагуудад орон тоо гарсан нөхцөлд олон нийт, хамт олны оролцоог хангасан,мэдлэг ур чадварт суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог тогтолцоог дагаж мөрдөнө.

4.1.3. Иргэдээс төрийн алба, албан тушаалтантай холбоотой авлига,хээл хахууль, ашиг сонирхолын зөрчлийн талаар гаргасан мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

4.2.Төсөв санхүү

4.2.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2.Төсвийн зардлыг ач холбогдолоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, алдагдлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, сумын төсвийн чадавхийг нэмэгдүүлнэ.

4.2.3. Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.

4.3. Сум, багийн хөгжил.

4.3.1.Сумандаа дэд бүтцийг нь бүрэн шийдсэн 30-50 айлын хувийн хаус хороолол, орон сууцыг хувийн хэвшилтэй хамтарч ашиглалтад оруулна.

4.3.2. Сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод,хүнсний ногоо тариалж, орчноо ногооруулна.

4.3.3. Багийн төвүүдийг шинэчлэх төслийг сэргээж, үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.3.4. Сумын төвийг цэвэр бохирын шугамд холбоно.

4.3.5.Сумын төвдөө хатуу хучилттай замтай болох асуудлыг шийднэ.

4.3.6. Сумын төвийн зонхилох салхин талд ногоон байгууламж бий болгоно.

4.4. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах

4.4.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, төв суурин газар, тодорхой цэгүүдийг телекамерийн хяналтад авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.4.2. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулж “Архигүй Баянцагаанчууд ” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.4.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй сум ” болохыг зорино.

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН АРДЧИЛСАН НАМ

